

Нэг. Ерөнхий мэдээлэл, Мэдээлэл цуглуулах

Бид дараах зорилгоор таны мэдээллийг бүртгэж авдаг бөгөөд энэ нь таньд илүү үр өгөөжтэй, боловсронгуй үйлчилгээг үзүүлэхэд оршино. Үүнд:

1. Хэрэглэгч FACEBOOK хаягаар Zescoin Wallet платформд бүртгэл үүсгэсэн бол хэрэглэгчийн мэдээллийг FACEBOOK–с авах бөгөөд (Овог, Нэр, Нүүр зураг гэх мэт) хэрэглэгчийн нийтэд ил болгохыг зөвшөөрсөн мэдээллүүд системд хадгалагдаж хэрэглэгчийн бүртгэл үүсгэх болно.
2. Хэрэглэгч хувийн мэдээллээ оруулах үед мэдээлэл (өөрийн овог нэр, нас, хүйс, улс, өөрийн зураг, имэйл гэх мэт ерөнхий мэдээллүүд) системд хадгалагдана.
3. Хэрэглэгчид шинэ мэдээ мэдээлэл, үйлчилгээг хүргэх
4. Имэйл илгээх: Бид хэрэглэгчийн болон үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой мэдээлэл илгээхэд тэдний имэйл хаягийг ашигладаг. Түүнчлэн хэрэглэгчийн асуулт, хүсэлт, лавлагаанд хариу өгөхөд ашиглана. Хэрэглэгч манай имэйлийн жагсаалтад бүртгүүлбэл Секлабын мэдээлэл, нийтлэлүүдийг имэйлээр хүлээж авна. Хүссэн үедээ энэ жагсаалтаас хасуулж болно. Илгээж байгаа имэйл бүрийн төгсгөлд жагсаалтаас хасуулах холбоос бий.
5. Таны ирүүлсэн мэдээллийн дагуу бид үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж, илүү бүтээлчээр ажиллах боломжтой болно.

Хоёр. Хэрэглэгчийн мэдээллийг хэрхэн ашиглах вэ?

1. Манай платформд бүртгүүлэхээр хүсэлт илгээхэд FACEBOOK–с авсан мэдээллийн (Овог, Нэр, Нүүр зураг гэх мэт) дагуу бүртгэл үүсгэх
2. Манай үйлчилгээнд хандах / бидэнтэй холбогдоход таныг таньж баталгаажуулах/
3. Хуулийн болон зохицуулах байгууллагуудтай хамтран ажиллаж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх
4. Шаардлагатай тохиолдолд хуулийн дагуух эрхээ эдлэх, жишээ нь, хууль зөрчиж буй үйлдлийг илрүүлэх
5. Гадаад ашиглалт: Бид хэрэглэгчийн хувийн мэдээллийг гадагш худалдах, задлах үйлдэл хийхгүй болно.

Гурав. Мэдээллийн аюулгүй байдал

1. Манай талбарт хадгалагдсан таны хувийн мэдээлэл, хэрэглэгчийн нэр, нууц үг, гүйлгээний мэдээлэл, өгөгдөлд зөвшөөрөлгүй хандах, хувиргах, илчлэх, устгахаас хамгаалахын тулд бид өгөгдөл цуглуулах, хадгалах, боловсруулах болон аюулгүй байдлын зохих арга хэрэгслийг авч ашигладаг.

Дөрөв. Хэрэглэгч мэдээллээ хэрхэн устгах вэ?

1. Хэрэв та Zescoin Wallet платформд бүртгэлтэй хэрэглэгчийн мэдээллээ устгуулах хүсэлтэй байгаа бол info@seclab.mn и-мэйл хаягт хүсэлтээ илгээнэ үү. Хүсэлт илгээхдээ өөрийн Zescoin Wallet-т баталгаажсан и-мэйл хаяг болон хэрэглэгчийн нэр `/@username/` тодорхой бичиж илгээх хэрэгтэй. Бид таныг эрх бүхий хэрэглэгч мөн эсэхийг шалгахын тулд и-мэйл эсвэл утсаар дахин баталгаажуулахыг шаардаж болно. Бид таны хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт хэрэглэгчийн бүртгэл болон хэрэглээний түүх зэрэг мэдээллийг устгаж танд мэдэгдэх болно.
2. Хэрэглэгчийн хувийн мэдээлэл устгагдсанаар хэрэглээний түүх зэрэг мэдээлэл дахин сэргээх боломжгүйгээр устгагдах тул та хүсэлт гаргахын өмнө сайтар бодож үзэхийг анхаарна уу!
3. Хэрэв танд ямар нэгэн асуудал тулгарсан бол бидэнтэй info@seclab.mn болон facebook пэйжийн чатад холбогдоно уу.